



**ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/62

Баян-Өндөр сум

**Засаг даргын нөөц сангаас
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар хурлын шийдвэрт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Баян-Өндөр сумын Спорт цогцолборын дэргэдэх Хангарьд спорт клубын усанд сэлэлтийн тамирчин, спортын мастер Ц.Энхриймаа, Т.Цэндсүрэн, Б.Номин-Эрдэнэ нар нь Филиппин Улсын Нью Кларк хотноо болох 11 дэх удаагийн өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тул нэг удаагийн буцалтгүй дэмжлэг 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн шаардлагатай зардлыг баталсугай.

2.Дээрх зардлыг сумын Засаг даргын нөөц сангаас гаргахыг Нягтлан бодогч (А.Адъяадолжин)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Өлзийбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАНСҮРЭН



6124010046